

**“ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ”-ИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД
ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦОО**

УЛААНБААТАР ХОТ

2023

АГУУЛГА

| | |
|--|----|
| УДИРТГАЛ..... | 3 |
| Үнэлгээний хамрах хүрээ | 4 |
| Нэг. Төрийн байгууллагын зардал | 11 |
| 1.1. Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, зарцуулах хугацаа | 11 |
| 1.2. Ажил үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөц | 16 |
| 1.3. Нийт гарах хүний нөөцийн зардлын тооцоо, холбогдох нэмэлт зардал | 18 |
| 1.4. Бусад нэмэлт зардал, нийт зардлын урьдчилсан тооцоо, хувилбар | 23 |
| Хоёр. Иргэнд үүсэх зардал, ачаалал | 26 |
| 1.1. Иргэдэд шинээр үүссэн үүрэг | 26 |
| 1.2. Хугацаа, зардлын тооцоо..... | 27 |
| 1.3. Тоон үзүүлэлт, нийт ачаалал /зардал, хугацаа/ | 28 |
| 1.4. Бусад зардал..... | 29 |
| Гурав. Хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардал | 30 |
| Үнэлгээний үр дүн | 31 |
| Хавсралт 1: Хуулийн төсөлд тусгасан төрийн байгууллагын үүрэг..... | 35 |
| Хавсралт 2: Хуулийн төсөлд тусгагдсан хэрэгжүүлэгч байгууллагын үүргийн стандарт үйл ажиллагаа..... | 39 |
| Хавсралт 3: Хэрэгжүүлэх үйл ажиллагаа буюу үүргийн талаарх тоон үзүүлэлт | 42 |
| Хавсралт 4: Шүүхийн байгууллагад шинээр бий болсон үүрэгтэй холбогдох стандарт үйл ажиллагаа..... | 43 |
| Хавсралт 5: Захиалагчаас ирүүлсэн хуулийн төсөл | 46 |

Хүснэгтийн жагсаалт

| | |
|---|----|
| Хүснэгт 1. Зардал тооцох үе шат, алхам /төрийн байгууллага/..... | 4 |
| Хүснэгт 2. Төрийн байгууллагын хүний нөөцийн зардлыг урьдчилан тооцох зохицуулалт..... | 4 |
| Хүснэгт 3. Шүүхэд үүсэх хүний нөөцийн зардлыг урьдчилан тооцох зохицуулалт..... | 6 |
| Хүснэгт 4. Нэмэлт зардлын хүрээнд тооцох буюу санхүүгийн зардлыг тооцох заалтууд /үйл ажиллагаа, үйлчилгээгээр/..... | 7 |
| Хүснэгт 5. Зардал тооцох үе шат, алхам /иргэн/..... | 9 |
| Хүснэгт 6. Иргэнд шинээр ачаалал бий болгосон заалт /Сайн дураар биелүүлэх/..... | 9 |
| Хүснэгт 7. Хэрэгжүүлэгч байгууллагуудын үүрэг..... | 12 |
| Хүснэгт 8. Хэрэгжүүлэгч байгууллагуудын гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагаанд зарцуулах хугацаа | 13 |
| Хүснэгт 9. Шүүхийн хүний нөөцийн зардлыг урьдчилан тооцох заалтууд..... | 14 |
| Хүснэгт 10. Шүүхийн гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагаанд зарцуулах хугацаа | 16 |
| Хүснэгт 11. Хэрэгжүүлэгч байгууллагын гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагаанд шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээ /нийт цаг/..... | 16 |
| Хүснэгт 12. Шүүхэд бий болох хүний нөөцийн хэрэгцээ /нийт цаг/..... | 17 |
| Хүснэгт 13. Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагаанд шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээ /орон тоо/..... | 18 |
| Хүснэгт 14. Шаардлагатай орон тооны цалингийн зэрэглэл, хэмжээ | 19 |
| Хүснэгт 15. Нэг албан хаагчид ногдох цалингийн зардал, орон тоо тус бүрээр | 19 |
| Хүснэгт 16. Төрийн байгууллагын хүний нөөцийн нийт зардал..... | 20 |
| Хүснэгт 17. Нэг албан хаагчид гарах материаллаг зардлын хэмжээ | 21 |
| Хүснэгт 18. Төрийн байгууллагуудын 1 жилийн хүний нөөцийн нийт зардал | 22 |
| Хүснэгт 19. Санхүүгийн зардал буюу нэмэлт зардал тооцох заалтууд..... | 23 |
| Хүснэгт 20. Нэмэлт зардлын урьдчилсан тооцоо | 24 |
| Хүснэгт 21. Орон тооны бус Зөвлөлийн цалингийн зардал | 25 |
| Хүснэгт 22. Иргэнд шинээр ачаалал бий болгосон заалт /Сайн дураар биелүүлэх/.... | 26 |
| Хүснэгт 23. Үргийг гүйцэтгэх шаардлагатай хугацаа болон зардал..... | 27 |
| Хүснэгт 24. Иргэдээд бий болох нийт зардал | 28 |
| Хүснэгт 25. Сэтгэл санааны хохирол тоогоолгоход хувь хүнд үүсэх ачаалал..... | 29 |
| Хүснэгт 26. Төрийн байгууллагын үүрэг, байгууллагаар..... | 35 |
| Хүснэгт 27. Хэрэгжүүлэгч байгууллагуудын гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагаа | 39 |
| Хүснэгт 28. Шүүхэд үүсэх стандарт үйл ажиллагаа..... | 43 |

УДИРТГАЛ

Энэхүү тайланд Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зардлын тооцоог Засгийн газрын 2016 оны 59 тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын /цаашид Аргачлал гэх/ дагуу гүйцэтгэж, хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах захиргааны зардлыг урьдчилан тооцов.

Хууль тогтоомжийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо нь 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр хэрэгжиж буй Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хийгддэг бөгөөд тодорхой харилцааг зохицуулах зорилгоор шинээр боловсруулж буй хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээр төрийн байгууллага, хуулийн этгээд болон хувь хүнд хэр хэмжээний зардал, ачаалал үүсэх магадлалыг урьдчилан гаргах зорилготой. Энэ нь аливаа хууль тогтоомжийн улмаас улс орны эдийн засаг болон иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсч байгаа захиргааны зардал, ачааллыг аль болох бага үүсгэх зохицуулалтын хувилбарыг боловсруулахад чухал ач холбогдолтой.

Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл /цаашид хуулийн төсөл гэх/ нь гэр бүлийн харилцааны эрх зүйн орчинг сайжруулах, гэр бүлийн харилцаанд тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэх төдийгүй гэр бүлийн харилцааг олон улсын жишигт нийцүүлэх, шинээр үүсч байгаа асуудлыг зохицуулах, орхигдсон асуудлууд буюу хийдлийг арилгах үндсэн зорилготой¹.

Энэ хүрээнд тус хуулийн төслөөр хуулийн этгээдэд шинээр үүрэг бий болгоогүй бөгөөд иргэнд үүсэх ачааллын хувьд сайн дураар биелүүлэх зарим төрлийн шинэ зохицуулалт тусгагдсан. Харин төрийн байгууллагын тухайд хуулийг хэрэгжүүлэгч байгууллагуудад тодорхой шинэ үүрэг бий болгосон. Тодруулбал, хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, үрчлэлтийн талаарх зохицуулалтын хүрээнд, мөн Засаг даргын үүрэгт хамаарч байсан тодорхой үүргүүдийг шилжүүлсэнтэй холбоотойгоор салбарын холбогдох төрийн байгууллагуудад шинэ үүрэг үүссэн. Түүнчлэн хүүхдийг үрчлүүлэх эсэхийг үрчлэлтийн асуудал хариуцсан орон тооны бус Үрчлэлтийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэх шинэ зохицуулалт орсон тул шүүхэд нэмэлт ачаалал бий болно.

Иймд төрийн байгууллагад үүсэх зардлыг тоймлон гаргаснаар хуулийн хэрэгжилтийг бүрэн хангахад шаардлагатай нэмэлт зардлыг урьдчилан тооцох нь тус тайлангийн үндсэн зорилго байх болно.

¹ Хуулийн төслийн үзэл баримтлалаас.

Үнэлгээний хамрах хүрээ

Хуулийн төслөөс сонгон зардал тооцох зохицуулалт буюу үнэлгээний хүрээний тухайд Аргачлалын дагуу иргэн, хуулийн этгээдэд шинээр үүссэн үүрэг, харилцаанаас үүсэх зардал, ачааллыг тооцох буюу өмнө байсан харилцааг зохицуулсан зохицуулалтад өөрчлөлт ороогүй бол зардал, ачааллыг тооцдоггүй. Төрийн байгууллагын хувьд өмнө нь хэрэгжүүлж байсан чиг үүрэгт өөрчлөлт ороогүй бол мөн зардал тооцохгүй бөгөөд хуулийн төсөлд хамаарах үндсэн хэрэгжүүлэгч агентлагт үүсэх ачаалал болон улсын төсөвт их хэмжээгээр үүсгэх зардлыг голчлон тооцох зарчмыг баримталдаг.

Тус хуулийн төслийн хувьд хуулийн этгээдэд шинэ ачаалал үүсгэх зохицуулалт тусгагдаагүй. Иймд хуулийн төслөөс дараах зохицуулалтуудыг сонгон төрийн байгууллага, иргэнд үүсэх зардал, ачааллыг тооцов. Үүнд:

1. Төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцох зохицуулалт

Дээр дурдсанчлан үндсэн хэрэгжүүлэгч агентлагт үүсэх ачаалал, зардлыг тооцох нь ихэнх тохиолдолд хангалттай байдаг боловч энэхүү хуулийн төслийн цар хүрээнээс хамааран нэг бус нилээд хэдэн байгууллагын ачааллыг зайлшгүй тооцох шаардлагатай болж байна. Ингэхдээ Аргачлалд заасны дагуу төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг дараах үе шатаар тус бүр тооцно. Үүнд:

Хүснэгт 1. Зардал тооцох үе шат, алхам /төрийн байгууллага/

**Төрийн
байгууллагад
үүсэх
зардал,
ачаалал**

- Үүргийг тогтоох
- Хүний нөөцийг тодорхойлох
- Гарах зардлыг тооцох
- Зардлыг нэгтгэн тооцож гаргах
- Хувилбарыг нягталж, танилцуулах

Өөрөөр хэлбэл төрийн байгууллагын зардлын хүрээнд тухайн ажил үйлчилгээг /шинээр бий болох үүргийг/ гүйцэтгэхэд шаардагдах **(а) хүний нөөцийн хэрэгцээг** тодорхойлж, түүнд шаардагдах зардал болон холбогдох бусад **(б) нэмэлт зардлыг** тооцно. Үүнд:

(а). Хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох зохицуулалт

Аргачлалаар тогтоосон үе шат, дарааллын дагуу стандарт үйл ажиллагааг тодорхойлж, тэдгээрт зарцуулах цаг хугацааг тооцох боломжтой, хэрэгжүүлэгч агентлагуудын дараах үүргийн хүний нөөцийн зардлыг тооцон гаргана. Үүнд:

Хүснэгт 2. Төрийн байгууллагын хүний нөөцийн зардлыг урьдчилан тооцох зохицуулалт

| № | Зохицуулалт | Зардал тооцох үүрэг |
|--|--|--|
| 1. Гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага | | |
| 1 | 37.4.Хүүхдийн төрөл, садантайгаа харилцахыг хориглосон тухай маргааныг шүүх шийдвэрлэхдээ гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас гаргах <u>хүүхдийн төрөл, садантайгаа харилцах харилцааны үнэлгээний саналыг үндэслэн шийдвэрлэнэ.</u> | Хүүхдийн төрөл садантайгаа харилцах харилцааны үнэлгээ хийх |
| 2. Аймаг, сум, дүүргийн гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан байгууллага | | |
| 2 | 65.5.Энэ хуулийн 90.1.9-д заасан эрх бүхий байгууллага <u>урчлүүлэх хүүхэд, үрчлэн авах гэр бүлийн нөхцөл байдалд үнэлгээг хийж Зөвлөлд хүргүүлнэ.</u> | Үрчлүүлэх хүүхэд, үрчлэн авах гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ хийх |
| 3 | 69.2.Гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан нь <u>урчлэлтийн мэдээллийн сан бүрдүүлнэ.</u> | Мэдээллийн сан хөтлөх, мэдээлэл оруулах /урчлэлтийн/ |
| 4 | 90.1.5.гэр бүлийн асуудлаар <u>салбар дундын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх;</u> | Дундын нэгдсэн сан хөтлөх, мэдээлэл оруулах |
| 3. Сум, хорооны гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан | | |
| 5 | 67.3.Аймаг, дүүргийн гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага үрчлэгчийг <u>гэр бүл, эцэг, эх, хүүхдийн харилцааны талаар зохих сургалт, мэргэжлийн зөвлөгөөгөөр хангана.</u> | Мэргэжлийн зөвлөгөөө өгөх/үрчлэгчид/ |
| 6 | 58.2.Энэ хуулийн 55.2, 55.3-т заасан <u>хүний зан төлөв, ахуйн нөхцөл байдлын үнэлгээг</u> аймаг, сум, дүүргийн гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан байгууллага хийж, дүгнэлт, мэдээллийг аймаг, дүүргийн Засаг даргад хүргүүлнэ. 93.1.7.хүүхдийг асран хамгаалах, харгалзан дэмжлэг хамруулахад тохиолдолд <u>нөхцөл байдлын үнэлгээ хийж, дүгнэлт гаргах, хяналт тавих;</u> | Зан төлөв, ахуйн нөхцөл байдлын үнэлгээ хийх /хүүхдийг асран хамгаалах, харгалзан дэмжлэг хамруулахад/ |

- 7 58.5.Сум, хорооны гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан асран хамгаалалт, харгалзан дэмжлэгт байгаа хүний нөхцөл байдлын үнэлгээ, асран хамгаалалт, харгалзан дэмжлэг тогтоосон шийдвэр, гэрээ, төрсний гэрчилгээ, эрүүл мэндийн төвийн дүгнэлт, оршин суугаа газрын хаяг, төрөл, садангийн хүний тухай мэдээлэл, эд хөрөнгийн жагсаалт, бусад бичиг баримтаас бүрдсэн хувийн хэрэг нээж, бүрдүүлнэ.

4. Харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага

- 8 84.1.Харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь гадаад үрчлэлтийн мэдээллийн сан бүрдүүлнэ.
- 9 84.3.Харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тухайн үрчлэгч гэр бүлтэй, эсхүл энэ хуулийн 83.5-д заасан итгэмжлэгдсэн байгууллагатай гэрээ байгуулна.

Түүнчлэн шүүхэд үүсэх хүний нөөцийн зардал, ачааллыг тусад нь авч үзэв. Ингэхдээ, тодорхой харилцааг шинээр зохицуулсан хэдий ч зайлшгүй шүүхээр шийдвэрлэх гэрээний маргаан, гэм бурууг тогтоох зэрэг асуудлыг зохицуулсан зүйл, заалтыг энд тооцоогүй болно. Өөрөөр хэлбэл ачааллыг тооцож гаргасан ч зохицуулалтын өөр хувилбар, хялбарчлах боломж хязгаарлагдмал зохицуулалтын хувьд стандарт үйл ажиллагаа гарган, ачааллыг тооцох шаардлагагүй юм. Ийнхүү дараах зохицуулалтын хүрээнд шүүхэд үүсэх хүний нөөцийн зардал буюу ачааллыг нарийвчлан тооцов. Үүнд:

Хүснэгт 3. Шүүхэд үүсэх хүний нөөцийн зардлыг урьдчилан тооцох зохицуулалт

| № | Зохицуулалт | Шинээр үүссэн үүрэг | Одоо хэрэгжиж зохицуулалт | байгаа |
|---|-------------|---------------------|---------------------------|--------|
|---|-------------|---------------------|---------------------------|--------|

- 1 67.2.Шүүх Зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн хүүхдийг үрчлүүлэх эсэх шийдвэрийг гаргана. Хүүхэд үрчлүүлэх эсэх тухай шийдвэр гаргах 55.7.Сум, дүүргийн Засаг дарга хүүхэд үрчлэн авах тухай хүсэлтийг хянан үзэж, үрчлүүлэх эсэх тухай шийдвэрийг 20 хоногт багтаан гаргана.

- 2 83.7.Үрчлэлтийн зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн хүүхэд үрчлүүлэх асуудлыг шүүх шийдвэрлэнэ. Гадаадад хүүхэд үрчлүүлэх эсэх тухай шийдвэр гаргах 58.1.Гадаадын иргэн Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах тухай хүсэлтээ өөрийн орны эрх бүхий байгууллагаар дамжуулан Монгол Улсын эрх бүхий байгууллагад гаргана.
- 3 25.2.Хүүхдийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийг өөрчлөх хүсэлтийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, 16 нас хүрсэн хүүхэд өөрөө оршин суугаа газрын анхан шатны шүүхэд гаргана². Хүүхдийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийг өөрчлөх хүрсэн хүүхэд өөрөө оршин суугаа газрын анхан шатны шүүхэд гаргана². Гадаадад хүүхэд үрчлүүлэх эсэх тухай шийдвэр гаргах 12.1.Иргэн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нээрээ өөрчлөх бол дараах баримт бичгийг бүрдүүлж, оршин суугаа газрын улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлнэ:
 12.1.1.өргөдөл;
 12.1.2.төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэх, эсхүл гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, эсхүл паспортыг орлох баримт бичиг.

(б). Нэмэлт зардал тооцоход хамаарах зохицуулалт

Бусад нэмэлт зардлын /хүний нөөцийн бус зардлын/ хүрээнд сургалт зохион байгуулах, мэдээллийн сан үүсгэх зэрэг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн зардлыг тойм байдлаар баримжаалан гаргана. Үүнд:

Хүснэгт 4. Нэмэлт зардлын хүрээнд тооцох буюу санхүүгийн зардлыг тооцох заалтууд /үйл ажиллагаа, үйлчилгээгээр/

| № | Зохицуулалт | Хэрэгжүүлэх байгууллага |
|---|-------------|-------------------------|
| 1. Програм хангамж, технологийн зардал | | |

- 1 90.1.5.гэр булийн асуудлаар салбар дундын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх; Гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага

² Захиалагчаас ирүүлсэн хуулийн төсөлд тус зохицуулалтыг 2 хувилбараар оруулсан. Нөгөө хувилбар нь одоо хэрэгжиж байгаа зохицуулалт болно.

2. Танхим байгуулах зардал

- 2 86.2.Аймаг, нийслэл, дүүргийн гэр бүл, хүүхдийн Аймаг, сум, дүүргийн гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан нэгж нь гэр бүлд зөвлөгөө, уйлчилгээ үзүүлэх сургалт, мэдээлэл арга зүйн төв, танхимтай байна.

3. Хамтын ажиллагаа, үйлчилгээний хөлс

- 3 83.5.Хүүхдийг үрчлүүлэхдээ гадаад улсын эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэй итгэмжлэгдсэн төрийн захиргааны байгууллага байгууллагыг сонгож, хамтран ажиллана.

4. ДНХ-ийн мэдээллийн сан үүсгэх зардал

- 4 5.4.Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ батлуулахаас Шүүх шинжилгээний байгууллага хоорондоо садан, төрлийн холбоотой эсэхээ мэдэх зорилгоор ДНХ (Дезоксирибонуклейн хүчил)-ийн шинжилгээнд хамрагдаж болно.

5. Орон тооны бус Зөвлөлийн цалин

- 5 65.1.Хүүхдийг үрчлэх асуудлыг эцэг, эх хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагчийн зөвшөөрөл болон энэ хуулийн 67.1-д заасны дагуу Үрчлэлийн зөвлөлийн /цаашид “Зөвлөл” гэх/ дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.

- 6 83.6.Харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд Монгол Улсын харьят хүүхдийг гадаадын гэр бүл, иргэнд үрчлүүлэх талаар дүгнэлт гаргах үүрэг бүхий Гадаад Үрчлэлийн зөвлөл ажиллана.

2. Иргэнд шинээр үүсэх зардал, ачааллыг тооцох зохицуулалт:

Иргэнд үүсэх ачааллын хувьд хуулийн төсөлд сайн дураар биелүүлэх зарим төрлийн шинэ зохицуулалт тусгагдсан бөгөөд энэ хүрээнд иргэнд үүсэх ачааллыг Аргачлалд заасны дагуу дараах үе шатаар тус бүр тооцно. Үүнд:

Хүснэгт 5. Зардал тооцох уе шат, алхам /иргэн/

Иргэнд үүсэх зардал, ачаалал

- Үүргийг тогтоох
- Хугацаа зардал тооцох
- Тоон үзүүлэлтийг тооцох
- Нийт дүнг тооцож гаргах
- Хувилбарыг нягталж, хялбарчлах боломжийг шалгах

Өөрөөр хэлбэл иргэнд үүсэх зардал, ачааллын хүрээнд хуулийн төсөлд тусгагдсан үүргийг гүйцэтгэхтэй холбогдуулан гарах мөнгөн зардлаас гадна зарцуулах хугацаа буюу ачааллыг тооцно. Үүнд:

Хүснэгт 6. Иргэнд шинээр ачаалал бий болгосон заалт /Сайн дураар биелүүлэх/

| № | Холбогдох зохицуулалт | Тооцох зардал |
|---|---|---|
| 1 | 5.2.Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ батлуулахаас өмнө сайн дураараа, харилцан тохиролцсоны үндсэн дээр эрүүл мэндийн шинжилгээ өгч, эрх бүхий байгууллагаас зохион байгуулж байгаа гэр бүлийн боловсрол олгох сургалтад хамрагдаж болно. | Эрүүл мэндийн шинжилгээ өгөх, сургалтад хамрагдах зардал, хугацаа |
| 2 | 5.3.Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ батлуулахаас өмнө хоорондоо садан, төрлийн холбоотой эсэх лавлагааг иргэний бүртгэлийн байгууллагаас авч болно. | Садан төрлийн холбоотой эсэх лавлагааг авахад гарах зардал, хугацаа |
| 3 | 5.4.Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ батлуулахаас хоорондоо садан, төрлийн холбоотой эсэхээ мэдэх зорилгоор ДНХ (Дезоксирибонуклейн хүчил)-ийн шинжилгээнд хамрагдаж болно. | ДНХ шинжилгээ өгөх зардал, хугацаа |
| 4 | 5.5.Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ бүртгүүлэхдээ нөгөө талын өмнөх гэрлэлтийн лавлагаа болон хүүхэдтэй эсэх мэдээллийг иргэний бүртгэлийн байгууллагаас авч болно. | Лавлагаа авахад гарах зардал, хугацаа |
| 5 | 7.1.Энэ хуулийн 5.2-т заасны дагуу гэрлэхийг хүсэгчид сэтгэцийн эрүүл мэндийн, хүний дархлал | Эрүүл мэндийн шинжилгээ өгөх зардал, хугацаа |

хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдол, бэлгийн замын халдвар, сүрьеэ өвчин, удамшлын эмгэгтэй эсэхийг тогтоох эрүүл мэндийн шинжилгээнд хамрагдаж болно.

Түүнчлэн хуулийн төсөлд тодорхой харилцаатай холбоотойгоор сэтгэл санааны хохирол тогтоолгох зохицуулалтууд тусгагдсан бөгөөд (тухайлбал, хуулийн төслийн 70.6-д “Үрчлэлтийн үйл явц нь хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн байх бөгөөд хүүхдэд сэтгэл санааны болон эд хөрөнгийн хохирол учруулахыг хориглоно”) иргэнд үүсэж болзошгүй бусад зардлын хүрээнд сэтгэл санааны хохирол тогтоолгоход хувь хүнд үүсэх зардал, ачааллыг мөн дунджаар тодорхойлов.

Нэг. Төрийн байгууллагын зардал

Энэ хэсэгт хуулийн төслийн төрийн захиргааны байгууллагад үүрэг оногдуулсан зохицуулалтууд нь тухайн байгууллагад буюу төрд хэдий хэр ачаалал, зардал үүсгэх магадлалтайг баримжаалан тооцно. Төрийн байгууллагад үүсэх ачаалал, зардлын хэмжээг урьдчилан тооцох нь тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх төсөв, санхүүжилтийн хэмжээ, хэрэгцээ, шаардлагыг тогтоох, мөн хэрэгжих боломжийг тодорхойлоход ач холбогдолтой.

Төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардлыг дараах үе шатаар тооцно. Үүнд:

- Үүргийг тогтоох
- Хүний нөөцийг тодорхойлох
- Гарах зардлыг тооцох
- Зардлыг нэгтгэн тооцож гаргах
- Хувилбарыг нягталж, танилцуулах

Үүнд, стандарт үйл ажиллагааг тогтоож, хүний нөөцийн зардал буюу зарцуулах цаг хугацааг тооцох боломжтой үүргийг дээрх дарааллын дагуу тооцож нэгтгэн гаргах бол сургалт зохион байгуулах, мэдээллийн сан үүсгэх зэрэгт шаардагдах санхүүгийн зардлыг бусад нэмэлт зардлын хүрээнд тойм байдлаар баримжаалан гаргана.

1.1. Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, зарцуулах хугацаа

Хуулийн төсөлд Засгийн газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Гадаад харилцааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Аймаг, сум, дүүргийн гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан байгууллага, Сум, хорооны гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан, Аймаг, сум, дүүргийн Засаг дарга, Харьятын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон Шүүхийн байгууллагад шинээр үүрэг оноосон зохицуулалтууд тусгагдсан байна /Хавсралт 1/. Эдгээрээс тохиолдлын тоог нь тогтоох боломжгүй болон тогтоох шаардлагагүй үйл ажиллагаа буюу хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, бодлого боловсруулах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэхэд гарах зардлыг тооцохгүй.

Ийнхүү Аргачлалд заасны дагуу хуулийн төсөл дэх төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, ажил үйлчилгээнд хамааралтай бүх байгууллагыг биш шинэ чиг үүрэг нэмэгдэж байгаа гол хэрэгжүүлэгч байгууллагуудыг сонгон зардал, ачааллыг тооцов. Ингэхдээ стандарт үйл ажиллагааг тогтоох боломжтой үүрэг бүхий байгууллагуудын ачаалал, хүний нөөцийг аргачлалын дагуу үе шаттайгаар тооцох бөгөөд хүний нөөцийн бус, бусад зардлыг нэмэлт зардал тооцох хэсэгт шаардлагатай мөнгөн зардлыг нь тоймлон тооцно. Мөн салбарын агентлаг, байгууллагууд болон шүүхийн ачааллыг тус тусад нь авч үзнэ.

Хуулийн төсөлд стандарт үйл ажиллагааг нь тооцох шаардлагатай салбарын байгууллагуудын дараах үүрэг байна. Үүнд:

Хүснэгт 7. Хэрэгжүүлэгч байгууллагуудын үүрэг

| № | Зохицуулалт | Зардал тооцох үүрэг |
|--|--|--|
| 1. Гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага | | |
| 1 | 37.4.Хүүхдийн төрөл, садантайгаа харилцахыг хориглосон тухай маргааныг шүүх шийдвэрлэхдээ гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас гаргах <u>хүүхдийн төрөл, садантайгаа харилцах харилцааны үнэлгээний</u> саналыг үндэслэн шийдвэрлэнэ. | Хүүхдийн төрөл садантайгаа харилцах харилцааны үнэлгээ хийх |
| 2 | 65.5.Энэ хуулийн 90.1.9-д заасан эрх бүхий байгууллага <u>урчлүүлэх хүүхэд, үрчлэн авах гэр бүлийн нөхцөл байдалд үнэлгээг</u> хийж Зөвлөлд хүргүүлнэ. | Үрчлүүлэх хүүхэд, үрчлэн авах гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ хийх |
| 3 | 69.2.Гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан нь <u>урчлэлтийн мэдээллийн сан</u> бүрдүүлнэ. | Мэдээллийн сан хөтлөх, мэдээлэл оруулах /Урчлэлтийн/ |
| 4 | 90.1.5.гэр бүлийн асуудлаар <u>салбар дундын мэдээллийн нэгдсэн сан</u> бүрдүүлэх; | Дундын нэгдсэн сан хөтлөх, мэдээлэл оруулах |
| 2. Аймаг, сум, дүүргийн гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан байгууллага | | |
| 5 | 67.3.Аймаг, дүүргийн гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага үрчлэгчийг <u>гэр бүл, эцэг, эх, хүүхдийн харилцааны талаар</u> зохих сургалт, мэргэжлийн зөвлөгөөөр хангана. | Мэргэжлийн зөвлөгөөө өгөх/үрчлэгчид/ |
| 6 | 58.2.Энэ хуулийн 55.2, 55.3-т заасан <u>хүний зан төлөв, ахуйн нөхцөл байдлын үнэлгээг</u> аймаг, сум, дүүргийн гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан байгууллага хийж, дүгнэлт, мэдээллийг аймаг, дүүргийн Засаг даргад хүргүүлнэ. | Зан төлөв, ахуйн нөхцөл байдлын үнэлгээ хийх |
| | 93.1.7.хүүхдийг асран хамгаалах, харгалзан дэмжлэг хамруулахад тохиолдолд <u>нөхцөл байдлын үнэлгээ</u> хийж, <u>дүгнэлт</u> гаргах, хяналт тавих; | /Хүүхдийг асран хамгаалах, харгалзан дэмжлэг хамруулахад/ |

3. Сум, хорооны гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан

- 7 58.5.Сум, хорооны гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан асран хамгаалалт, харгалзан дэмжлэгт байгаа хүний нөхцөл байдлын үнэлгээ, асран хамгаалалт, харгалзан дэмжлэг тогтоосон шийдвэр, гэрээ, төрсний гэрчилгээ, эрүүл мэндийн төвийн дүгнэлт, оршин суугаа газрын хаяг, төрөл, садангийн хүний тухай мэдээлэл, эд хөрөнгийн жагсаалт, бусад бичиг баримтаас бүрдсэн хувийн хэрэг нээж, бурдуулнэ.

Хувийн хэрэг нээж
бурдуулэх

/асран хамгаалалт,
харгалзан дэмжлэгт
байгаа хүний/

4. Харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага

- 8 84.1.Харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь гадаад үрчлэлтийн мэдээллийн сан бүрдүүлнэ.
- 9 84.3.Харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тухайн үрчлэгч гэр бүлтэй, эсхүл энэ хуулийн 83.5-д заасан итгэмжлэгдсэн байгууллагатай гэрээ байгуулна.

Мэдээллийн сан хөтлөх, мэдээлэл оруулах /гадаад үрчлэлтийн/

Гэрээ байгуулах /гадаад үрчлэлтийн/

Эдгээрийн стандарт үйл ажиллагааг тодорхойлох, зарцуулах хугацааг нь гаргахдаа одоо хэрэгжик байгаа адил төстэй үйлчилгээ байгаа эсэхийг судалж, холбогдох мэргэжилтнүүдийн саналыг авсан бөгөөд тэдний гүйцэтгэсэн ажил үйлчилгээгээр баримжаалж тогтоосон. Тодруулбал, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 32 дугаар зүйлийн 32.1-т заасны дагуу нийгмийн ажилтан, хохирогч нь хүүхэд бол Хүүхэд хамгааллын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3-т заасны дагуу нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан, шаардлагатай тохиолдолд аймаг, дүүрэгт хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хүүхэд, гэр бүлийн мэргэжилтэн, суманд нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн Хамтарсан багийн бусад гишүүнтэй хамтран хийдэг нөхцөл байдлын үнэлгээг жишиг болгов. Улмаар жишиг үнэлгээнд үндэслэн гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагааг алхам тус бүрээр нарийвчлан тодорхойлж /Хавсралт 2/, түүнд зарцуулах нийт хугацааг гаргав. Үүнд:

Хүснэгт 8. Хэрэгжүүлэгч байгууллагуудын гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагаанд зарцуулах хугацаа

Үйл ажиллагаа буюу үүрэг

Стандарт үйл ажиллагаа

Нийт
зарцуулах

Гэр бүл, хүүхдийн асуудал Хүүхдийн төрөл садантайгаа 12 хариуцсан төрийн захиргааны харилцах харилцааны үнэлгээ хийх байгууллага

Үрчлүүлэх хүүхэд, үрчлэн авах гэр 12 бүлийн нөхцөл байдлын үнэлгээ хийх

Мэдээллийн сан хөтлөх, мэдээлэл 0,5 оруулах

Дундын нэгдсэн сан хөтлөх, мэдээлэл 0,5 оруулах

Аймаг, сум, дүүргийн гэр бүл, Мэргэжлийн зөвлөгөө өгөх 1,5 хүүхдийн асуудал хариуцсан байгууллага Зан төлөв, ахуйн нөхцөл байдлын 12 үнэлгээ

Сум, хорооны гэр бүл, Хувийн хэрэг нээж бүрдүүлэх 6 хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан

Харьяатын асуудал хариуцсан Мэдээллийн сан хөтлөх, мэдээлэл 0,5 төрийн захиргааны оруулах байгууллага

Гэрээ байгуулах 12

Харин шүүхэд үүсэх хүний нөөцийн зардал, ачааллын тухайд аливаа харилцааг шинээр зохицуулсанаас үүдэн бий болж буй хэдий ч зайлшгүй шүүхээр шийдвэрлэх гэрээний маргаан, гэм бурууг тогтоох зэрэг асуудлыг зохицуулсан зүйл, заалтыг тооцоогүй болно³. Өөрөөр хэлбэл ачааллыг тооцож гаргасан ч зохицуулалтын өөр хувилбар, хялбарчлах боломж хязгаарлагдмал зохицуулалтын хувьд стандарт үйл ажиллагаа гарган, ачааллыг тооцох шаардлагагүй юм. Иймд дараах зохицуулалтын хүрээнд шүүхэд үүсэх хүний нөөцийн зардал буюу ачааллыг тооцов. Үүнд:

Хүснэгт 9. Шүүхийн хүний нөөцийн зардлыг урьдчилан тооцох заалтууд

³ Эдгээрийг Судалгааны 1.3 хэсэгт ерөнхийлөн тооцоолж, шүүхэд үүсэх магадлалтай ачаалалд нэмж авч үзсэн.

| № | Заалт | Шинээр үүссэн үүрэг | Өмнөх зохицуулалт |
|----------|--|---|---|
| 1 | 67.2.Шүүх Зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн хүүхдийг үрчлүүлэх эсэх шийдвэрийг гаргана. | Хүүхэд үрчлүүлэх эсэх тухай шийдвэр гаргах | 55.7.Сум, дүүргийн Засаг дарга хүүхэд үрчлэн авах тухай хүсэлтийг хянан үзэж, үрчлүүлэх эсэх тухай шийдвэрийг 20 хоногт багтаан гаргана. |
| 2 | 83.7.Үрчлэлтийн зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн хүүхэд үрчлүүлэх асуудлыг шүүх шийдвэрлэнэ. | Гадаадад хүүхэд үрчлүүлэх эсэх тухай шийдвэр гаргах | 58.1.Гадаадын иргэн Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах тухай хүсэлтээ өөрийн орны эрх бүхий байгууллагаар дамжуулан Монгол Улсын эрх бүхий байгууллагад гаргана. |
| 3 | 25.2.Хүүхдийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийг өөрчлөх хүсэлтийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, 16 нас хүрсэн хүүхэд өөрөө оршин суугаа газрын анхан шатны шүүхэд гаргана ⁴ . | Хүүхдийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийг өөрчлөх эсэх тухай шийдвэр гаргах | 12.1.Иргэн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрээ өөрчлөх бол дараах баримт бичгийг бүрдүүлж, оршин суугаа газрын улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлнэ: 12.1.1.өргөдөл; 12.1.2.төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэх, эсхүл гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, эсхүл паспортыг орлох баримт бичиг. |

Шүүхэд үүсэж буй үүргийн стандарт үйл ажиллагааны хувьд Шүүгчийн ажлын ачаалал тодорхойлох судалгааг⁵ ашиглан хэрэгжүүлэх алхам, хугацааг гаргасан. Тус судалгаанд үндэслэн шүүхийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагааг алхам тус бүрээр нарийвчлан тодорхойлж /Хавсралт 4/, түүнд зарцуулах нийт хугацааг дараах байдлаар гаргав. Үүнд:

⁴ Захиалагчаас ирүүлсэн хуулийн төсөлд энэ зохицуулалтыг 2 хувилбараар тусгасан.

⁵ Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүгчийн ажлын ачаалал тодорхойлох судалгаа, Хүснэгт 20. Шүүгчийн ажлын ачаалал тодорхойлох үзүүлэлт /Иргэний хэргийн анхан шатны шүүх/, хуудас 32.

Хүснэгт 10. Шүүхийн гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагаанд зарцуулах хугацаа

| № | Үйл ажиллагаа буюу үүрэг | Зарцуулах хугацаа /цаг/ |
|---|---|-------------------------|
| 1 | Хүүхэд үрчлүүлэх эсэх тухай шийдвэр гаргах | 8 |
| 2 | Гадаадад хүүхэд үрчлүүлэх эсэх тухай шийдвэр гаргах | 14.5 |
| 3 | Хүүхдийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийг өөрчлөх эсэх тухай шийдвэр гаргах | 8 |

1.2. Ажил үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөц

Энэ хэсэгт тухайн ажил үйлчилгээг жилд хэдэн удаа гүйцэтгэх тоог урьдчилан таамагласнаар шаардлагатай нийт хүний нөөцийг тооцож гаргана. Ингэхдээ тохиолдлын тоог үйл ажиллагаа тус бүрийн хүрээнд зохих статистик мэдээ, дундаж үзүүлэлтэд тулгуурлан гаргасан **/Хавсралт 3/**. Үүнд:

Хүснэгт 11. Хэрэгжүүлэгч байгууллагын гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагаанд шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээ /нийт цаг/

| Байгууллага | Төрийн гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ | байгууллагын садантайгаа харилцах харилцааны үнэлгээ хийх | Зарцуу лах хугацаа /цаг/ | Тохиолдлын тоо | Хүний нөөцийн хэрэгцээ /нийт цаг/ |
|---|--|---|--------------------------|----------------|-----------------------------------|
| Гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага | Хүүхдийн садантайгаа харилцах харилцааны үнэлгээ хийх | төрөл 12 авах гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ хийх | 170 | 2040 | |
| | Үрчлүүлэх хүүхэд, үрчлэн авах гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ хийх | 12 | 1480 | 17760 | |
| | Мэдээллийн сан хөтөлөх, 0,5 мэдээлэл оруулах | 0,5 | 1480 | 740 | |
| | Дундын нэгдсэн сан хөтөлөх, 0,5 мэдээлэл оруулах | 0,5 | 9348 | 4674 | |

| | | | |
|---|--|------|--------------|
| | Нийт | | 25214 |
| Аймаг, сум, дүүргийн гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан байгууллага | <i>Мэргэжлийн зөвлөгөө өгөх</i> | 1,5 | |
| | | 1480 | 2220 |
| | <i>Зан төлөв, ахуйн нөхцөл байдлын үнэлгээ</i> | 12 | |
| | | 42 | 504 |
| | Нийт | | 2724 |
| Сум, хорооны гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан | <i>Хувийн хэрэг нээж бүрдүүлэх</i> | 6 | |
| | | 42 | 252 |
| | Нийт | | 252 |
| Харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага | <i>Мэдээллийн сан хөтлөх, 0,5 мэдээлэл оруулах</i> | 11 | 5.5 |
| | <i>Гэрээ байгуулах</i> | 12 | |
| | | 11 | 132 |
| | Нийт | | 137.5 |

Шүүхийн хувьд шинээр ирж буй үүрэгт зарцуулах хүний нөөцийг урьдчилан гаргахын тулд мөн тухайн харилцаа тус бүрийн өмнөх жилүүдийн тоон үзүүлэлтийн дундажыг тооцоолон /Хавсралт 3/ тохиолдлын тоог авч үзсэн. Үүнд:

Хүснэгт 12. Шүүхэд бий болох хүний нөөцийн хэрэгцээ /нийт цаг/

| Үйл ажиллагаа буюу үүрэг | Зарцуулах хугацаа тоо /цаг/ | Тохиолдлын тоо | Хүний нөөцийн хэрэгцээ /нийт цаг/ |
|--------------------------|--------------------------------|----------------|-----------------------------------|
|--------------------------|--------------------------------|----------------|-----------------------------------|

| | | | |
|---|------|------|-------|
| Хүүхэд үрчлүүлэх эсэх тухай шийдвэр гаргах | 8 | 1480 | 11840 |
| Гадаадад хүүхэд үрчлүүлэх эсэх тухай шийдвэр гаргах | 14.5 | 11 | 160 |
| Хүүхдийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийг өөрчлөх эсэх тухай шийдвэр гаргах | 8 | 167 | 1336 |

Улмаар нэг албан хаагч жилд 200 ажлын өдөр ажилладаг гэж үзвэл жилд 1600 цаг ажиллах бөгөөд нийт шаардлагатай цагийг шаардлагатай орон тоонд шилжүүлэн байгууллага тус бүрээр авч үзвэл дараах тооцоо гарч байна. Үүнд:

Хүснэгт 13. Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагаанд шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээ /орон тоо/

| № | Байгууллага | Хүний нөөцийн хэрэгцээ/нийт цаг/ | Хүний нөөцийн хэрэгцээ /орон тоо/ |
|---|--|----------------------------------|-----------------------------------|
| 1 | Гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага | 25214 | 16 |
| 2 | Аймаг, сум, дүүргийн гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан байгууллага | 2724 | 1.7 |
| 3 | Сум, хорооны гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан | 252 | 0.15 |
| 4 | Харьятын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага | 137.5 | 0.08 |
| 5 | Шүүх | 13335 | 8 |

Нийт

26

Өөрөөр хэлбэл хуулийн төслийн улмаас төрийн байгууллагуудад нийт 26, үүнээс салбарын байгууллагуудад 18, **шүүхэд 8 орон тооны /шүүгч/ ачаалал тус тус бий болгох тооцоо гарч байна.** Эдгээрээс шүүхийн ачаалал нь зөвхөн шаардлагатай шүүгчийн орон тоо бөгөөд улмаар мөн тооны шүүгчийн туслахын орон тоо нэмэгдэх юм. Иймд шүүхэд нийт 8 шүүгч, 8 туслахын орон тоо бий болох тооцоо гарч байна.

1.3. Нийт гарах хүний нөөцийн зардлын тооцоо, холбогдох нэмэлт зардал

Нийт гарах хүний нөөцийн зардлын урьдчилсан тооцоо хийхэд дараах төрлийн зардлын мэдээлэл цуглувлав. Үүнд:

- Цалин, бусад нэмэгдэл, тусламж

- Ажлын байрны, цахилгааны болон бусад материаллаг зардал
- Дагалдах бусад зардал

Өмнөх хэсэгт төрийн байгууллагуудад нийт 26, үүнээс салбарын байгууллагуудад 18, шүүхэд 8 орон тоо шаардлагатай гэж тооцсон. Иймд нийт 26 орон тоотой холбогдох хүний нөөцийн зардлыг тухайн байгууллагын цалингийн зэрэглэл тус бүрээр тооцох шаардлагатай болж байна.

Цалингийн хэмжээний тухайд байгууллага бүрт шаардлагатай орон тоо тус бүрээр цалингийн зэрэглэлийн дундаж цалингийн хэмжээг тогтоов. Үүнд:

Хүснэгт 14. Шаардлагатай орон тооны цалингийн зэрэглэл, хэмжээ

| Албан тушаалын зэрэглэл | Албан тушаалын зэрэглэл | Сарын цалингийн хэмжээ /мян төг/ |
|--|-------------------------|----------------------------------|
| Гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага | T3-9 | 791.532 |
| Аймаг, сум, дүүргийн гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан байгууллага | T3-9 | 717.662 |
| Сум, хорооны гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан | TY-7 | 766.540 |
| Харьятын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага | T3-9 | 791.532 |
| Шүүх | Анхан шатны шүүгч | 2 700.000 |

Түүнчлэн цалингийн хэмжээг тогтооход үндсэн цалингаас гадна тодорхой нэмэгдлүүдийг⁶ тооцох шаардлагатай бөгөөд эдгээрийн хэмжээг тодорхой гаргах боломжгүй ч нийтлэг зардлыг үндсэн цалингийн 15%, дагалдах зардал болон нэмэгдэл, урамшууллыг 10%-аар тус тус тооцов. Үүнд:

Хүснэгт 15. Нэг албан хаагчид ногдох цалингийн зардал, орон тоо тус бүрээр

⁶ Бүх төрлийн даатгал, хоол унааны нэмэгдэл, ажилласан жилийн нэмэгдэл, зэрэг дэвийн нэмэгдэл, шагнал урамшуулал зэрэг болно.

| Үндсэн цалингийн дундаж хэмжээ | Нийтлэг зардал-15% | Дагалдах зардал-10% | Нэмэгдэл, урамшууллын зардал-10% | Нийт цалин |
|--------------------------------------|-----------------------|------------------------|--|-----------------|
| 791532 | 118729.8 | 79153.2 | 79153.2 | 1001288 |
| 717662 | 107649.3 | 71766.2 | 71766.2 | 907842.4 |
| 766540 | 114981 | 76654 | 76654 | 969673.1 |
| 791532 | 118729.8 | 79153.2 | 79153.2 | 1001288 |

Шүүгч

| | | | |
|-------------------------------|---|---------------------------------|------------|
| Үндсэн цалингийн хэмжээ | Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл- 5% | Онцгой нөхцлийн нэмэгдэл-40% | Нийт цалин |
|-------------------------------|---|---------------------------------|------------|

2700000 135000 1080000 **3915000**

Ийнхүү байгууллага тус бүрт шаардлагатай орон тооны сарын цалинг дунджаар тооцсон бөгөөд нийт шаардлагатай хүний нөөцийн цалингийн зардлыг байгууллага тус бүрээр дор тооцов. Үүнд:

Хүснэгт 16. Төрийн байгууллагын хүний нөөцийн нийт зардал

| Нэмэгдэж буй ачаалал /орон тоо/ | Цалингийн зардал /мян төг/ | Хүний нөөцийн нийт зардал / сая төг/ | Нийт зардал – 1 жилд /сая төг/ |
|------------------------------------|-------------------------------|--|--------------------------------------|
|------------------------------------|-------------------------------|--|--------------------------------------|

Гэр бүл, хүүхдийн
асуудал хариуцсан
төрийн захиргааны
байгууллага /16 орон тоо/
1001.288 16.020608 192.247292

Аймаг, сум, дүүргийн гэр
бүл, хүүхдийн асуудал
хариуцсан байгууллага
/1.7 орон тоо/
907.842 1.543332 18.519986

Сум, хорооны гэр бүл,
хүүхдийн асуудал
969.673 0.145451 1.745411

хариуцсан нийгмийн
ажилтан /0.15 тоо/

| | | | |
|----------------------------|----------|-----------|------------|
| Харьяатын асуудал | | | |
| хариуцсан төрийн | | | |
| захиргааны байгууллага | | | |
| /0.08 тоо/ | 1001.288 | 0.080103 | 0.961236 |
| Шүүх /8 орон тоо - шүүгч/ | 3915 | 31.32 | 375.84 |
| Шүүх /8 орон тоо - туслах/ | 1858 | 14.864704 | 178.376448 |

Түүнчлэн цалингаас гадна материаллаг зардлыг авч үзэх шаардлагатай бөгөөд эдгээр байгууллага нь шинээр бий болох орон тоог хангах материаллаг нөөцтэй гэж үзэн бичгийн ширээ, компьютер зэрэг тоног төхөөрөмж шинээр авахтай холбоотой зардал тооцоогүй бөгөөд харин эдгээртэй холбоотой элэгдэл, хороодлын зардлыг тооцсон. Мөн материаллаг зардлын нарийвчилсан тооцоо гаргахдаа “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”-д жишээ болгон авсан ХЗДХЯ-ы нэг ажилтны материаллаг зардлыг ашиглав. Үүнд:

Хүснэгт 17. Нэг албан хаагчид гарах материаллаг зардлын хэмжээ

| Зардлын нэр | Зардлын төрөл | Хэмжээ /төгрөг/ |
|--|----------------------|-----------------|
| Урсгал зардал | Бичиг хэргийн зардал | 124,000 |
| | Ном, хэвлэл авах | 54,745 |
| | Шуудан холбоо | 306,812 |
| | Нийт | 485,557 |
| Барилга, байгууламж, өрөө тасалгааны зардал | Түлш, халаалт | 263,408 |
| | Гэрэл, цахилгаан | 128,239 |
| | Цэвэр, бохир ус | 599,438 |
| | Урсгал зардал | 127,752 |
| | Газрын төлбөр | 22,253 |

| | | |
|--------------------|-----------------------------------|------------------|
| | Нийт | 1,141,090 |
| Элэгдэл, зардал | хорогдлын Техник, тоног төхөөрөмж | 160,000 |
| | Тавилга, эд хогшил | 100,000 |
| | Барилга, байгууламж | 65,670 |
| | Нийт | 325,670 |
| Нийт | | 1,952,317 |

Дээрх тооцооноос үзэхэд нэг албан хаагчид гарах материаллаг зардлын хэмжээ дунджаар 1,952,317 төгрөг байна. Тус тооцоог ашиглан хуулийн төслийн улмаас төрийн байгууллага буюу төсөвт үүсэх нийт хүний нөөцийн ачаалал, зардлыг тооцож гаргав. Үүнд:

Хүснэгт 18. Төрийн байгууллагуудын 1 жилийн хүний нөөцийн нийт зардал

| Байгууллага – шаардлагатай орон тоо | Хүний нөөцийн зардал /цалин, саяг төг/ | Материаллаг зардал /сая төг/ | Нийт зардал /сая төг/ |
|-------------------------------------|--|------------------------------|-----------------------|
|-------------------------------------|--|------------------------------|-----------------------|

| | | | |
|---|------------|-----------|------------|
| Гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага /16 орон тоо/ | 192.247292 | 31.237072 | 223.484364 |
| Аймаг, сум, дүүргийн гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан байгууллага /1.7 орон тоо/ | 18.519986 | 3.318939 | 21.838924 |
| Сум, хорооны гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан /0.15 тоо/ | 1.745411 | 0.292847 | 2.038259 |
| Харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага /0.08 тоо/ | 0.961236 | 0.156185 | 1.117421 |

| | | | |
|----------------------------|-------------------|-----------|------------|
| Шүүх /8 орон тоо - шүүгч/ | 375.84 | 15.618536 | 391.458536 |
| Шүүх /8 орон тоо - туслах/ | 178.376448 | 15.618536 | 193.994984 |
| Нийт | 833.932490 | | |

Ийнхүү төрд 1 жилд нийт 834 сая төгрөгийн хүний нөөцийн зардал нэмэгдэх, үүнээс **хэрэгжүүлэгч агентлагийн** хүний нөөцийн нийт зардал 248 сая, шүүхэд нэмэгдэх хүний нөөцийн зардал 585 сая төгрөг байх тооцоо гарч байна.

Энэхүү тооцооллоос үзэхэд төрийн байгууллагад нийт 34 хүний орон тоо шинээр үүсгэх хэмжээний ачаалал нэмэгдэж байгаа тул энэ ачааллыг өнөөгийн байгаа хүний нөөцийн хүрээнд шийдвэрлэснээр хууль бүрэн төгс хэрэгжихгүй байх нөхцөл байдал үүсэх эрсдэлтэй байна.

1.4. Бусад нэмэлт зардал, нийт зардлын урьдчилсан тооцоо, хувилбар

Төсвийн зардал багасгах, ачаалал бууруулах, зохицуулалтын өөр хувилбар хэрэгжүүлэх боломж байгаа эсэхийг шалгах зорилгоор хуулийн төсөлтэй холбоотой гарч байгаа төрийн байгууллагад үүсэх бусад нэмэлт зардлыг энд авч үзэв.

Үүнд, стандарт үйл ажиллагааг тогтоож, хүний нөөцийн зардал буюу зарцуулах цаг хугацааг тооцох боломжтой үүргийг дээрх дарааллын дагуу тооцож нэгтгэн гаргах бол сургалт зохион байгуулах, мэдээллийн сан үүсгэх зэрэгт шаардагдах санхүүгийн зардлыг энд бусад нэмэлт зардлын хүрээнд тойм байдлаар баримжаалан гаргасан болно. Тус зорилгоор дараах зохицуулалтуудын хүрээнд зардал тооцно. Үүнд:

Хүснэгт 19. Санхүүгийн зардал буюу нэмэлт зардал тооцоо заалтууд

| № | Зохицуулалт | Хэрэгжүүлэх байгууллага |
|---|---|---|
| 1. Програм хангамж, технологийн зардал | | |
| 1 | 90.1.5.гэр бүлийн асуудлаар <u>салбар дундын</u> <u>мэдээллийн нэгдсэн сан</u> бүрдүүлэх; | Гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага |
| 2. Танхим байгуулах зардал | | |
| | | |

- 2 86.2.Аймаг, нийслэл, дүүргийн гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан нэгж нь гэр бүлд зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх сургалт, мэдээлэл арга зүйн төв, танхимтай байна.
- Aймаг, сум, дүүргийн гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан байгууллага

3. Хамтын ажиллагаа, үйлчилгээний хөлс

- 3 83.5.Хүүхдийг үрчлүүлэхдээ гадаад улсын эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэй итгэмжлэгдсэн төрийн захиргааны байгууллага байгууллагыг сонгож, хамtran ажиллана.

4. ДНХ-ийн мэдээллийн сан үүсгэх зардал

- 4 5.4.Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ батлуулахаас Шүүх шинжилгээний байгууллага хоорондоо садан, төрлийн холбоотой эсэхээ мэдэх зорилгоор ДНХ (Дезоксирибонуклейн хүчил)-ийн шинжилгээнд хамрагдаж болно.

5. Орон тооны бус Зөвлөлийн цалин

- 5 65.1.Хүүхдийг үрчлэх асуудлыг эцэг, эх хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагчийн зөвшөөрөл болон энэ хуулийн 67.1-д заасны дагуу Үрчлэлийн зөвлөлийн /цаашид “Зөвлөл” гэх/ дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.
- Үрчлэлийн зөвлөл

- 6 83.6.Харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд Монгол Улсын харьят хүүхдийг гадаадын гэр бүл, иргэнд үрчлүүлэх талаар дүгнэлт гаргах үүрэг бүхий Гадаад Үрчлэлийн зөвлөл
- Гадаад Үрчлэлийн зөвлөл ажиллана.

Дээрх зардлуудын тооцоог баримжаалан гаргахдаа тухайн улсын төсөв, холбогдох байгууллагын төсөвт өмнөх жилүүдэд тусгагдсан ижил төстэй зардлыг жишиг болгосон /Хавсралт 3/ бөгөөд дараах тооцоо гарч байна. Үүнд:

Хүснэгт 20. Нэмэлт зардлын үрьдчилсан тооцоо

| № | Байгууллага | Үйл ажиллагаа | Зардлын баримжаа | Тохиол дол | Нийт зардал /сая төг/ |
|---|-------------|---------------|------------------|------------|-----------------------|
|---|-------------|---------------|------------------|------------|-----------------------|

| | | | | | |
|-------------|---|-------------------------------------|------|--------------------|-------------|
| 1 | <i>Гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага</i> | Програм хангамж, технологийн зардал | 146 | 1 | 146 |
| 2 | <i>Аймаг, сум, дүүргийн гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан байгууллага</i> | Танхим тохижуулалт | 6 | 30 | 180 |
| 3 | <i>Харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага</i> | Хамтын ажиллагаа, ўйлчилгээний хөлс | 8,7 | 11 | 95.7 |
| 4 | <i>Шүүх Шинжилгээний Ерөнхий Газрын ДНХ-ий шинжилгээний лабораторийн зардал</i> | ДНХ-ийн мэдээллийн сан ўусгэх | 0.12 | 32400 ⁷ | 3888 |
| Нийт | | | | | 4310 |

Ийнхүү хуулийн төсөл хэрэгжиж өхэлсэнээр эдгээр зохицуулалтын хүрээнд нийт **4,310,000,000** төгрөгийн нэг удаагийн зардал гарах тооцоо гарч байна.

Түүнчлэн гадаад болон дотоод үрчлэлтийн асуудлаар дүгнэлт гаргах орон тооны бус Зөвлөлийн 1 жилийн цалингийн зардлыг тооцов⁸.

Хүснэгт 21. Орон тооны бус Зөвлөлийн цалингийн зардал

| № | Зөвлөлийн нэр | 1 цалин | жилийн /сая | Тохиолдлын тоо /орон тоо/ төг/ | Нийт зардал |
|-------------|--------------------------------|------------|----------------|--------------------------------------|-------------|
| 1 | <i>Үрчлэлийн зөвлөл</i> | 6 | | 5 | 30 |
| 2 | <i>Гадаад Үрчлэлийн зөвлөл</i> | 12 | | 5 | 60 |
| Нийт | | | | | 90 |

⁷ Суурь судалгаанд хамруулах шаардлагатай хүний тоо, зарцуулах зардлыг Шүүх Шинжилгээний Ерөнхий Газрын ДНХ-ий шинжилгээний лабораториос албан бичгээр тодруулсан.

⁸ Стандарт ўйл ажиллагаа тогтоох шаардлагагүй, тогтсон цалин тул энд тооцов.

Ийнхүү хуулийн төслийн хүрээнд бий болох 2 орон тооны бус Зөвлөлийн цалин 1 жилд ойролцоогоор 90,000,000 төгрөгийн зардал үүсгэх юм.

Хоёр. Иргэнд үүсэх зардал, ачаалал

Энэ хэсэгт Аргачлалын дагуу хуулийн төсөлд заасан үүргийг хэрэгжүүлэхэд иргэнд үүсэх зардал, ачааллын хүрээнд хууль тогтоомжид тусгагдсан үүргийг гүйцэтгэхтэй холбогдуулан гарах мөнгөн зардлаас гадна зарцуулах хугацаа буюу ачааллыг тооцно. Ингэхдээ тус хуулийн төсөл нь шинэ хууль буюу анхдагч хуулийн төсөл бус шинэчилсэн найруулга тул шинээр үүрэг, ачаалал бий болгосон зохицуулалтад л зардал тооцов. Зардлыг Аргачлалд заасны дагуу дараах 5 алхам буюу үе шатаар тооцов. Үүнд:

- Үүргийг тогтоох
- Хугацаа зардал тооцох
- Тоон үзүүлэлтийг тооцох
- Нийт дүнг тооцож гаргах
- Хувилбарыг нягталж, хялбарчлах боломжийг шалгах

1.1. Иргэдэд шинээр үүссэн үүрэг

Аргачлалд заасны дагуу иргэнд шинээр үүссэн үүрэг, харилцаанаас үүсэх зардал, ачааллыг тооцох буюу өмнө байсан харилцааг зохицуулсан зохицуулалтад өөрчлөлт ороогүй бол зардал, ачааллыг тооцдоггүй. Энэ хүрээнд тус хуулийн төсөлд иргэнд шинээр үүрэг хүлээлгэсэн /сайн дураар биелүүлэх/ дараах зохицуулалт байна. Үүнд:

Хүснэгт 22. Иргэнд шинээр ачаалал бий болгосон заалт /Сайн дураар биелүүлэх/

| № | Холбогдох зохицуулалт | Тооцох зардал |
|---|---|--|
| 1 | 5.2.Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ батлуулахаас өмнө сайн дураараа, харилцан тохиролцсоны үндсэн дээр эрүүл мэндийн шинжилгээ өгч, эрх бүхий байгууллагаас зохион байгуулж байгаа гэр бүлийн боловсрол олгох сургалтад хамрагдаж болно. | Эрүүл мэндийн шинжилгээ өгөх, Сургалтад хамрагдах |
| 2 | 5.3.Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ батлуулахаас өмнө хоорондоо садан, төрлийн холбоотой эсэх эсэх лавлагаа авах | Садан төрлийн холбоотой |

лавлагааг иргэний бүртгэлийн байгууллагаас авч болно.

- 3 5.4.Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ батлуулахаас ДНХ шинжилгээ өгөх хоорондоо садан, төрлийн холбоотой эсэхээ мэдэх зорилгоор ДНХ (Дезоксирибонуклейн хүчил)-ийн шинжилгээнд хамрагдаж болно.
- 4 5.5.Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ бүртгүүлэхдээ Гэрлэлтийн лавлагаа авах нөгөө талын өмнөх гэрлэлтийн лавлагаа болон хүүхэдтэй эсэх мэдээллийг иргэний бүртгэлийн байгууллагаас авч болно.
- 5 7.1.Энэ хуулийн 5.2-т заасны дагуу гэрлэхийг хүсэгчид сэтгэцийн эрүүл мэндийн, хүний дархлал хомсдолын вирусын халдварт, дархлалын олдмол хомсдол, бэлгийн замын халдварт, сурьеэ өвчин, удамшлын эмгэгтэй эсэхийг тогтоох эрүүл мэндийн шинжилгээнд хамрагдаж болно.

1.2. Хугацаа, зардлын тооцоо

Энэ хэсэгт тодорхойлсон үүргийг гүйцэтгэхэд иргэдээс зарцуулах цаг хугацаа, мөнгөн зардлыг тооцож гаргав. Ингэхдээ:

- Үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлж,
- Үйлдэлд зарцуулах хугацааг тогтоож,
- Тэдгээрт зарцуулах зардлыг тодорхойлов.

Иргэдэд үүсэх цаг хугацааны ачааллыг тооцоходоо стандарт үйл ажиллагааны жагсаалтад үндэслэж зарцуулах цаг хугацааг тодорхойлов. Үүнд:

Хүснэгт 23. Үүргийг гүйцэтгэх шаардлагатай хугацаа болон зардал

| № | Үйл ажиллагаа | Хугацаа /мин/ | Зардал /төг/ |
|---|--|---------------|--------------|
| 1 | Сургалтад хамрагдах | 90 | Үнэгүй |
| 2 | Садан төрлийн холбоотой эсэх лавлагаа авах | 30 | 1000 |

| | | | |
|-------------|------------------------------|------------|--------------|
| 3 | ДНХ шинжилгээ өгөх | 45 | 60000 |
| 4 | Гэрлэлтийн лавлагаа авах | 30 | 1000 |
| 5 | Эрүүл мэндийн шинжилгээ өгөх | 90 | Даатгал |
| Нийт | | 285 | 62000 |

Тайлбар: Үйл ажиллагааг гүйцэтгэх алхамыг тооцохдоо эмнэлгийн байгууллагын ажилтнаас зарцуулж болох хамгийн их болон бага хугацааг тодруулж, тэдгээрийн дунджаар тооцов.

Ийнхүү иргэн гэрлэлт бүртгүүлэх нөхцөлд хамаарах зохицуулалтыг сайн дураар биелүүлэхэд дунджаар **285 мин** зарцуулж, **62000** төгрөгийн мөнгөн зардал гаргах тооцоо гарч байна.

1.3. Тоон үзүүлэлт, нийт ачаалал /зардал, хугацаа/

Тоон үзүүлэлт нь хуулийн төсөлд тусгасан үүрэг хичнээн иргэдэд, нэг жилд хэдэн удаагийн давтамжтайгаар үүрэг хүлээлгэж байгааг илэрхийлнэ. Үүнд:

- Тохиолдлын тоо
- Дамтамжийн тоо

Тохиолдлын тоо, давтамжийн тоог тодорхойлсны дараа тэдгээрийн үржвэрийн тоон үзүүлэлт нь илэрхийлэгдэнэ. Эдгээр зохицуулалтын хувьд давтамжийн тоо 1 байна.

Улмаар өмнөх шатанд тооцож гаргасан үйл ажиллагаа нэг бүрийн зардлыг тоон үзүүлэлт үржүүлж нийт зардлын дүнг гаргавал дараах дүн гарна. Үүнд:

Хүснэгт 24. Иргэдэд бий болох нийт зардал

| № | Үйл ажиллагаа | Хугацаа /мин/ | Тохиолдол | Зардал /төг/ | Тохиолдол |
|---|---------------|------------------|-----------|--------------|-----------|
|---|---------------|------------------|-----------|--------------|-----------|

| | | | |
|---|---------------------|----|--------|
| 1 | Сургалтад хамрагдах | 90 | Үнэгүй |
|---|---------------------|----|--------|

| | | | |
|-------------|---|------------------|--------------------|
| 2 | Садан төрлийн 30 холбоотой эсэх лавлагаа авах | | 1000 |
| 3 | ДНХ шинжилгээ өгөх | 45 | 16188 |
| | | | 16188 |
| 3 | ДНХ шинжилгээ өгөх | 45 | 60000 |
| | | | |
| 4 | Гэрлэлтийн лавлагаа 30 авах | | 1000 |
| 5 | Эрүүл мэндийн 90 шинжилгээ өгөх | | Даатгалаас |
| Нийт | | 4 593 630 | 999 316 000 |

Ийнхүү хуулийн төсөлд тусгагдсан гэрлэх нөхцөлтэй холбогдох сайн дураар биелүүлэх зохицуулалтын хүрээнд **НИЙТ ТОХИОЛДЛООР** авч үзвэл иргэдэд **999 316 000** төг буюу 1 тэрбум орчим төгрөгийн зардлын ачаалал бий болно.

1.4 Бусад зардал

Хуулийн төсөлд тодорхой харилцаатай холбоотойгоор сэтгэл санааны хохирол тогтоолгох зохицуулалтууд тусгагдсан бөгөөд (тухайлбал, хуулийн төслийн 70.6-д “Үрчлэлтийн үйл явц нь хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн байх бөгөөд хүүхдэд сэтгэл санааны болон эд хөрөнгийн хохирол учруулахыг хориглоно”) иргэнд үүсэж болзошгүй бусад зардлын хүрээнд сэтгэл санааны хохирол тогтоолгоход хувь хүнд үүсэх зах зээлийн зардлыг мөн дунджаар тодорхойлов.

Шүүх шинжилгээний байгууллага нь Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 40.1-д заасны дагуу Эрүүгийн хуульд заасан тодорхой төрлийн гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршигийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргадаг. Харин хувийн эрх зүйн харилцааны хувьд /Иргэний хууль, 230 дугаар зүйл/ сэтгэл зүйч, сэтгэцийн эрүүл мэндийн мэргэшсэн эмчийн дүгнэлт, хувь хүний дүгнэлт зэрэгт үндэслэн нэхэмжлэгч өөрөө хохиролоо тогтоох практик нийтлэг байдлаар үйлчилж байна⁹. Өөрөөр хэлбэл сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжлийн оношилгоо, үйлчилгээнд үндэслэн тогтоох юм. Ингэхдээ, дараах хэмжээний ачаалал нэг удаад үүсч байна. Үүнд:

Хүснэгт 25. Сэтгэл санааны хохирол тогтоолгоход хувь хүнд үүсэх ачаалал

⁹ Өмгөөлөгчидтэй хийсэн ярилцлагад үндэслэв.

| № | Үйл ажиллагаа | Зарцуулах хугацаа /мин/ |
|---|--|-------------------------|
| 1 | Сэтгэцийн оношилгоо, үзлэг – Эмчид үзүүлэх | 30 |
| 2 | Сэтгэлзүйн сорил, дүгнэлт | 90 |
| 3 | Хохиролыг тооцох /мэргэжлийн зөвлөгөө/ | 90 |

Сэтгэл санааны хохирол тогтоолгоход хамгийн бага буюу нэг удаагийн эмчийн үзлэг, сэтгэлзүйн сорил өгөхөд дор хаяж 120 мин буюу нийт 2 цаг, сэтгэл санааны хохирол үүссэн гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд хохиролыг хууль зүйн зөвлөгөө, мэргэжлийн эмчийн зөвлөгөө зэрэгт үндэслэн зөвлөлдөн тогтооход дор хаяж 90 мин, нийт 210 мин буюу 3 цаг 30 минутыг хамгийн багадаа зарцуулах тооцоо гарч байна.

Мөнгөн зардлын хувьд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд эрүүл мэндийн даатгалаар оношилгоо, үзлэгт хамрагдахад мөнгөн зардал гарахгүй гэж тооцвол хохиролын хэмжээг тогтооход зөвлөгөө авах зардлыг хууль зүйн зөвлөгөө авах зардлаар тооцвол 1 цаг 30 минутын мэргэжлийн зөвлөгөө авах зардал дунджаар гарахаар байна.

Цаашид хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яам, Эрүүл мэндийн яам, Шүүхийн шинжилгээний байгууллага болон бусад холбогдох мэргэжлийн байгууллага хамтран зохих журам, аргачлал гаргаж стандарт тогтоох шаардлагатай. Ингэснээр иргэнд үүсэх ачаалал, зардал буурах боломжтой.

Гурав. Хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардал

Аргачлалд заасны дагуу тухайн харилцаанд оролцогч хуулийн этгээдийн гүйцэтгэх үүрэгт хуулиар үүрэг хүлээж буй хуулийн этгээдээс хуульд заасан тоо баримт, тайлан бусад мэдээллийг төрийн байгууллага буюу гуравдагч этгээдэд бэлтгэж өгөх, бэлэн байлгах, эсвэл мэдээлэл хүргүүлэхийг ойлгоно¹⁰. Харин энэхүү хуулийн төслийн хувьд хуулийн этгээдэд зардал, ачаалал үүсгэсэн зохицуулалт агуулаагүй байна.

¹⁰ Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт, Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо, 2.3 дах хэсэг.

Үнэлгээний үр дүн

Тус хуулийн төслөөр хуулийн этгээдэд шинээр үүрэг бий болгоогүй бөгөөд иргэнд үсэх ачааллын хувьд сайн дураар биелүүлэх зарим төрийн шинэ зохицуулалт тусгагдсан. Харин төрийн байгууллагын тухайд хуулийг хэрэгжүүлэгч байгууллагуудад тодорхой шинэ үүрэг бий болгосон. Үүнд:

Хэрэгжүүлэгч байгууллагуудад үсэх хүний нөөцийн зардал:

Хуулийн төслөөр төрийн байгууллагад шинэ үүрэг, ачаалал бий болгосон зохицуулалтын хүрээнд салбарын байгууллагуудад нийт 18 орон тоо шаардлагатай болох тооцоо гарав. Энэ хүрээнд төрд 1 жилд хэрэгжүүлэгч агентлагуудын хүний нөөцийн нийт зардал 248 сая төгрөгийн зардал нэмэгдэнэ.

Хүний нөөцийн ачааллыг байгууллагаар авч үзвэл:

- | | |
|---|---|
| 1 | Гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан 16 төрийн захиргааны байгууллага |
| 2 | Аймаг, сум, дүүргийн гэр бүл, 1.7 хүүхдийн асуудал хариуцсан байгууллага |
| 3 | Сум, хорооны гэр бүл, хүүхдийн 0.15 асуудал хариуцсан нийгмийн ажилтан |
| 4 | Харьяатын асуудал хариуцсан 0.08 төрийн захиргааны байгууллага |

Энэхүү тооцооллоос үзэхэд ГБХЗХГ-т нийт 16 орон тооны хэмжээний хүний нөөцийн ачаалал үсэх магадлалтай байна. Өөрөөр хэлбэл хуулийг хэрэгжүүлэгч үндсэн агентлагт үүсч байгаа энэ ачааллыг өнөөгийн байгаа хүний нөөцийн хүрээнд шийдвэрлэснээр хууль бүрэн төгс хэрэгжихгүй байх нөхцөл байдал үсэх эрсдэлтэй байна.

Түүнчлэн хуулийн төслийн хүрээнд бий болох 2 орон тооны бус Зөвлөлийн, тодруулбал Үрчлэлийн Зөвлөл болон Гадаад үрчлэлийн Зөвлөлийн цалин 1 жилд ойролцоогоор 90,000,000 төгрөгийн зардал үүсгэнэ.

Шүүхэд үсэх хүний нөөцийн зардал:

Аргачлалын дагуу стандарт үйл ажиллагаа тогтоон тооцоход шүүхэд 8 орон тооны /шүүгч/ ачаалал бий болох тооцоо гарч байна. Ингэхдээ стандарт үйл ажиллагаа тооцон гаргасан шүүхийн ачаалал нь зөвхөн шаардлагатай шүүгчийн орон тоо бөгөөд улмаар мөн тооны шүүгчийн туслахын орон тоо нэмэгдэх юм. Иймд шүүхэд нийт 8 шүүгч, 8 туслахын орон тоо бий болох тооцоо гарч байна.

Харин шаардлагатай хүний нөөцийн цалингийн зардлыг авч үзвэл шүүхэд нэмэгдэх хүний нөөцийн зардал 585 сая төгрөг байна.

Нийт хүний нөөцийн зардал:

Ийнхүү төрд 1 жилд нийт 834 сая төгрөгийн хүний нөөцийн зардал нэмэгдэх, үүнээс хэрэгжүүлэгч агентлагийн хүний нөөцийн нийт зардал 248 сая, шүүхэд нэмэгдэх хүний нөөцийн зардал 585 сая төгрөг байх тооцоо гарч байна.

Бусад нэмэлт зардал:

Хуулийн төсөл хэрэгжиж эхэлсэнээр стандарт үйл ажиллагааг тогтоож, хүний нөөцийн зардал буюу зарцуулах цаг хугацааг тооцох боломжгүй үүрэг буюу сургалт зохион байгуулах, мэдээллийн сан үүсгэх зэрэгт шаардагдах санхүүгийн зардлыг хүрээнд нийт **4,310,000,000** төгрөгийн нэг удаагийн зардал гарах тооцоо гарч байна. Үүнд:

| | | |
|--|-------------------------------------|---------|
| <i>Гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага</i> | Програм хангамж, технологийн зардал | 146 сая |
|--|-------------------------------------|---------|

| | | |
|---|--------------------|---------|
| <i>Аймаг, сум, дүүргийн гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан байгууллага</i> | Танхим тохижуулалт | 180 сая |
|---|--------------------|---------|

| | | |
|--|-------------------------------------|----------|
| <i>Харьяатын хариуцсан төрийн захиргааны байгууллага</i> | Хамтын ажиллагаа, үйлчилгээний хөлс | 95.7 сая |
|--|-------------------------------------|----------|

| | | |
|--|------------------------|------------------|
| <i>Шүүх Шинжилгээний Ерөнхий Газрын ДНХ-ийн шинжилгээний лаборатор</i> | ДНХ-ийн мэдээллийн сан | 3 888 сая үүсгэх |
|--|------------------------|------------------|

Үүнээс төсөвт ачаалал харьцангуй их үүсгэх зардал нь Шүүх Шинжилгээний Ерөнхий Газрын ДНХ-ийн шинжилгээний лабораторт ДНХ-ийн мэдээллийн сан үүсгэхэд зарцуулах нийт 4 тэрбум орчим төгрөгийн зардал болж байна. ДНХ-ийн мэдээллийн сан үүсгэхэд хүн амын төлөөлөх түвшнийг нийт хүн амын нэг хувь байхаар тогтооно гэж үзвэл суурь судалгаанд 32400 хүнийг хамруулах шаардлагатай бөгөөд **нэг хүнд хийгдэх судалгааны бодит зардал /дээж цуглуулах, ДНХ ялгах, ПГУ явуулах, капилляр электрофорези, мэдээллийн**

санд оруулах/-д **120-150 мянга орчим төгрөг** зарцуулахаар байна¹¹. Харин гэрлэлт бүртгүүлэх болон бусад шаардлагаар ДНХ-ийн шинжилгээ өгөхөд Шүүх Шинжилгээний Ерөнхий Газрын лабораторт 60,000 төг, хувийн эмнэлэгүүдийн лаборатори 70,000-90,000 төгрөгийн үнэлгээтэй байна.

Иргэнд үүсэх зардал, ачаалал:

Иргэнд үүсэх ачааллын хувьд хуулийн төсөлд сайн дураар биелүүлэх зарим төрлийн шинэ зохицуулалт тусгагдсан. Эдгээрийг авч үзвэл нэг иргэн гэрлэлт бүртгүүлэх нэхцэлд хамаарах зохицуулалтыг **сайн дураар** биелүүлэхэд дунджаар **285 мин** зарцуулж, **62000** төгрөгийн мөнгөн зардал гаргах тооцоо гарч байна. Үүнээс ДНХ-ийн шинжилгээ өгөхөд ихэнх зардал ноогдож байгаа юм. Дээр дурдсанчлан Шүүх Шинжилгээний Ерөнхий Газрын лабораторт 60,000 төг, хувийн эмнэлэгүүдийн лаборатори 70,000-90,000 төгрөгийн үнэлгээтэй байна. Харин **нийт тохиолдлоор** авч үзвэл иргэдэд **999 316 000** төг буюу 1 тэрбум орчим төгрөгийн зардлын ачаалал бий болно.

Бусад учирч болохуйц нэмэлт зардлын тухайд сэтгэл санааны хохирол тогтоолгох зардлыг авч үзсэн. Үүнд, сэтгэл санааны хохирол тогтоолгоход хамгийн бага буюу нэг удаагийн эмчийн үзлэг, сэтгэлзүйн сорил өгөхөд дор хаяж 120 мин буюу нийт 2 цаг, сэтгэл санааны хохирол үүссэн гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд хохиролыг хууль зүйн зөвлөгөө, мэргэжлийн эмчийн зөвлөгөө зэрэгт үндэслэн зөвлөлдөн тогтооход дор хаяж 90 мин, **нийт 210 мин буюу 3 цаг 30 минутыг хамгийн багадаа зарцуулах тооцоо гарч байна**¹².

Мөнгөн зардлын хувьд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд эрүүл мэндийн даатгалаар оношилгоо, үзлэгт хамрагдахад мөнгөн зардал гарахгүй гэж тооцвол хохиролын хэмжээг тогтооход зөвлөгөө авах зардлыг хууль зүйн зөвлөгөө авах зардлаар тооцвол 1 цаг 30 минутын мэргэжлийн зөвлөгөө авах зардал дунджаар гарахаар байна.

Цаашид хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яам, Эрүүл мэндийн яам, Шүүхийн шинжилгээний байгууллага болон бусад холбогдох мэргэжлийн байгууллага хамтран зохих журам, аргачлал гаргаж стандарт тогтоох шаардлагатай. Ингэснээр иргэнд үүсэх ачаалал, зардал буурах боломжтой.

¹¹ Суурь судалгаанд хамруулах шаардлагатай хүний тоо, зарцуулах зардлыг Шүүх Шинжилгээний Ерөнхий Газрын ДНХ-ийн шинжилгээний лабораториос албан бичгээр тодруулсаны үндсэн дээр урьдчилан тооцов.

¹² Шүүх шинжилгээний байгууллага нь Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 40.1-д заасны дагуу Эрүүгийн хуульд заасан тодорхой төрлийн гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргадаг. Харин хувийн эрх зүйн харилцааны хувьд /Иргэний хууль, 230 дугаар зүйл/ сэтгэл зүйч, сэтгэцийн эрүүл мэндийн мэргэшсэн эмчийн дүгнэлт, хувь хүний дүгнэлт зэрэгт үндэслэн нэхэмжлэгч өөрөө хохиролоо тогтоо практик нийтлэг байдлаар үйлчилж байна.

Хавсралт 1: Хуулийн төсөлд тусгасан төрийн байгууллагын үүрэг

Хүснэгт 26. Төрийн байгууллагын үүрэг, байгууллагаар

| № | Байгууллага | Холбогдох заалт | Зардал тооцох үүрэг | Стандарт үйл ажиллагаа тогтоох/Санхүү гийн зардал тооцох |
|---|---|---|------------------------------|--|
| 1 | Гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага | <p>37.4.Хүүхдийн төрөл, садантайгаа харилцахыг хориглосон тухай маргааныг шүүх шийдвэрлэхдээ гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас гаргах хүүхдийн төрөл, садантайгаа харилцах харилцааны үнэлгээний саналыг үндэслэн шийдвэрлэнэ.</p> | Үнэлгээ хийх | 37 дугаар зүйл: Шинэ зохицуулалт |
| | | <p>65.5.Энэ хуулийн 90.1.9-д заасан эрх бүхий байгууллага үрчлүүлэх хүүхэд, үрчлэн авах гэр бүлийн нөхцөл байдалд үнэлгээг хийж Зөвлөлд хүргүүлнэ.</p> | нөхцөл байдлын үнэлгээ хийх | Үнэлгээ хийх нь шинэ зохицуулалт |
| | | <p>69.2.Гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан нь үрчлэлтийн мэдээллийн сан бүрдүүлнэ.</p> | Мэдээллийн сан бүрдүүлэх | Шинэ үүрэг |
| | | <p>90.1.5.гэр бүлийн асуудлаар салбар дундын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх;</p> | Дундын нэгдсэн сан бүрдүүлэх | Шинэ үүрэг |
| | | <p>43.3.Хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зан үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөр боловсруулж, зохион байгуулна.</p> | | 43 дугаар зүйл: Шинэ зохицуулалт |

| | | | |
|---|--|---|---|
| | | <p>58.2.Энэ хуулийн 55.2, 55.3-т заасан хүний зан төлөв, ахуйн нөхцөл байдлын үнэлгээг аймаг, сум, дүүргийн гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан байгууллага хийж, дүгнэлт, мэдээллийг аймаг, дүүргийн Засаг даргад хүргүүлнэ.</p> | <p>Зан төлөв, Шинэ үүрэг ахуйн нөхцөл байдлын үнэлгээ</p> |
| 2 | Aймаг, сум, дүүргийн гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан байгууллага | <p>93.1.7.хүүхдийг асран хамгаалах, харгалзан дэмжлэг хамруулахад тохиолдолд нөхцөл байдлын үнэлгээ хийж, дүгнэлт гаргах, хяналт тавих;</p> | <p>67 дугаар зүйл: Шинэ зохицуулалт</p> |
| | | <p>67.3.Аймаг, дүүргийн гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага үрчлэгчийг гэр бүл, эцэг, эх, хүүхдийн харилцааны талаар зохих сургалт, мэргэжлийн зөвлөгөөгөөр хангана.</p> | |
| 3 | Сум, хорооны гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан | <p>86.2.Аймаг, нийслэл, дүүргийн гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан нэгж нь гэр бүлд зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх сургалт, мэдээлэл арга зүйн төв, танхимтай байна.</p> | <p>Танхим байгуулах, ажиллуулах</p> |
| | | <p>58.5.Сум, хорооны гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан асран хамгаалалт, харгалзан дэмжлэгт байгаа хүний нөхцөл байдлын үнэлгээ, асран хамгаалалт, харгалзан дэмжлэг тогтоосон шийдвэр, гэрээ, төрсний гэрчилгээ, эрүүл мэндийн төвийн дүгнэлт, оршин суугаа газрын хаяг, төрөл, садангийн хүний тухай мэдээлэл, эд хөрөнгийн жагсаалт, бусад бичиг баримтаас бүрдсэн хувийн хэрэг нээж, бүрдүүлнэ.</p> | <p>Хувийн хэрэг нээж бүрдүүлэх</p> |
| | | <p>92.1.5.асран хамгаалалт, харгалзан дэмжлэггүй хүнийг асран хамгаалалт, харгалзан дэмжлэгт</p> | |

| | | | | |
|---|---|---|---|--|
| | | хамруулах санал, дүгнэлтэд хяналт тавих; | | |
| 5 | Харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага | <p>84.1.Харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь гадаад үрчлэлтийн мэдээллийн сан бүрдүүлнэ.</p> <p>83.5.Хүүхдийг үрчлүүлэхдээ гадаад улсын эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэй итгэмжлэгдсэн байгууллагыг сонгож, хамтран ажиллана.</p> <p>84.3.Харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тухайн үрчлэгч гэр бүлтэй, эсхүл энэ хуулийн 83.5-д заасан итгэмжлэгдсэн байгууллагатай гэрээ байгуулна.</p> | <p>Мэдээллийн сан бүрдүүлэх</p> <p>Гээрэе байгуулах,</p> <p>Хамтын ажиллагаа, үйлчилгээ</p> | <p>Гадаад улсад үрчлэгдсэн хүүхдэд хяналт тавих нь шинэ зохицуулат</p> |
| 6 | Үрчлэлийн зөвлөл | <p>65.1.Хүүхдийг үрчлэх асуудлыг эцэг, эх хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагчийн зөвшөөрөл болон энэ хуулийн 67.1-д заасны дагуу Үрчлэлийн зөвлөлийн /цаашид “Зөвлөл” гэх/ дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.</p> <p>83.6.Харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд Монгол Улсын харьят хүүхдийг гадаадын гэр бүл, иргэнд үрчлүүлэх талаар дүгнэлт гаргах үүрэг бүхий Гадаад Үрчлэлтийн зөвлөл ажиллана.</p> | <p>зөвлөлийн цалин хөлс, урамшуулалт</p> | <p>Шинэ зохицуулалт</p> |
| 6 | Гадаад Үрчлэлийн зөвлөл | | | <p>Зөвлөлийн цалин хөлс, урамшуулалт</p> |

- Засгийн газар** – хуулийн төслийн 49.1-д заасан хүүхдийн тэтгэлгийн хэмжээ, хугацаа тогтоох аргачлалыг тогтоох,
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд** – Хүүхдийн төрөл, садантайгаа харилцах харилцааны үнэлгээ хийх журам, хуулийн төслийн 63.1, 63.2-т заасан хүүхдийн тэтгэлэг, тэтгэмжийг зарцуулах, хяналт тавих журам, үрчлүүлэх хүүхэд, үрчлэн авах гэр бүлийн нөхцөл байдалд үнэлгээ хийх журам, Үрчлэлийн зөвлөлийн ажиллах журам, хуулийн төслийн 69.2-т заасан мэдээллийн сан бүрдүүлэх, 69.3-т заасан үрчлэгдсэн хүүхдийн

эрхэд хяналт тавих журам, хуулийн төслийн 33.2-т заасан хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах этгээдийг томилох журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах;

- **Гадаад харилцааны сайд** - Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын харьяат гэр бүл, иргэнд үрчлүүлэх чиг үүрэг бүхий Үрчлэлтийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам, Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэгч талд үрчлүүлсний дараа хяналт тавих, үрчлэгч талтай гэрээ байгуулах журмыг тус тус хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах;
- **Хууль зүй, дотоод хэргийн сайд** – хуулийн төслийн 33.2-т заасан хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах этгээдийг томилох журмыг гэр бүл, хүүхдийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах, Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын харьяат гэр бүл, иргэнд үрчлүүлэх чиг үүрэг бүхий Үрчлэлтийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам, Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэгч талд үрчлүүлсний дараа хяналт тавих, үрчлэгч талтай гэрээ байгуулах журмыг тус тус гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах;
- **Гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага** – гэрлэгчдэд сургалт, зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах, магадлан итгэмжлэх журмыг батлах, 49.2-т заасан хүүхдийн тэтгэлгийн хэмжээ, хугацаа тогтоох аргачлалыг боловсруулах;
- **Гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага** - гэр бүлд зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх арга зүй, журмыг боловсруулж, хэрэгжүүлэх
- **Харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага** - Гадаадын харьяат гэр бүлтэй ярилцлага хийх журам батлах;
- **Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга** - Саадгүй, хүртээмжтэй орчин бүрдүүлж ажиллах талаар харья нутаг дэвсгэрийн байгууллага, иргэнд үүрэг даалгавар өгөх, биелэлтийг хангуулах, хяналт шалгалт хийх, тайлан бэлтгэж хэлэлцүүлэх, Саадгүй хүртээмжтэй орчин бүрдүүлэх талаар нутаг дэвсгэрийн хэмжээнд хүртээмжийн үнэлгээний ажил зохион байгуулах, цаашид хийх ажлын хүртээмжийн төлөвлөгөөг байгууллага, иргэнээр гаргуулан батлах үүрэг тус хүлээсэн байна.

Хавсралт 2: Хуулийн төсөлд тусгагдсан хэрэгжүүлэгч байгууллагын үүргийн стандарт үйл ажиллагаа

Жишиг тооцох үйл ажиллагаа: Нөхцөл байдлын үнэлгээ

Нөхцөл байдлын үнэлгээ гэж үйлчлүүлэгч, хүүхэд, гэр бүлд тулгарсан бэрхшээлийг шийдвэрлэх арга замыг тодорхойлохын тулд уг асуудалд холбоотой хүчин зүйлсийг тэдний хувийн болон нийгэм, хүрээлэн буй орчныг хамруулан цогц байдлаар судлах аргыг хэлнэ.

Нөхцөл байдлын үнэлгээг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 32 дугаар зүйлийн 32.1-т заасны дагуу нийгмийн ажилтан, хохирогч нь хүүхэд бол Хүүхэд хамгааллын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3-т заасны дагуу нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан, шаардлагатай тохиолдолд аймаг, дүүрэгт хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хүүхэд, гэр бүлийн мэргэжилтэн, суманд нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн Хамтарсан багийн бусад гишүүнтэй хамтран хийдэг.

Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид учирсан, эсхүл хүчирхийллийн болзошгүй эрсдэлд байгаа хүнд учирч болзошгүй сөрөг үр дагаврыг тодорхойлох, хариу үйлчилгээг төлөвлөх зорилгоор нөхцөл байдлын үнэлгээ хийнэ.

Санал, баталгаажуулалт: Ярилцлага /аймгийн гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын ажилтан/

Хүснэгт 27. Хэрэгжүүлэгч байгууллагуудын гүйцэтгэх үүрэг, стандарт үйл ажиллагаа

| Үйл ажиллагаа буюу үүрэг | Стандарт үйл ажиллагаа | Зарцуулах хугацаа /цаг/ |
|--|--|-------------------------|
| <i>Гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага</i> | | |
| Хүүхдийн төрөл садантайгаа харилцах үнэлгээ хийх | Уулзалт товлох, холбогдох мэдээлэл цуглуулах | 6 |
| Харилцааны үнэлгээ хийх | Уулзалт хийх, үнэлгээний маягтууд бөглөх | 4 |
| | Үнэлгээг баталгаажуулах, баримт цуглуулах | 2 |

| | | |
|--|--|-----|
| | Үнэлгээний дүгнэлт гаргах, баримт бүрдүүлэх | 1,5 |
| | Үнэлгээний материалыг эцэслэх | 0,5 |
| Үрчлүүлэх хүүхэд, үрчлэн авах гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ хийх | Үулзалт товлох, холбогдох мэдээлэл цуглуулах | 6 |
| | Үулзалт хийх, үнэлгээний маягтууд бөглөх | 4 |
| | Үнэлгээг баталгаажуулах, баримт цуглуулах | 2 |
| | Үнэлгээний дүгнэлт гаргах, баримт бүрдүүлэх | 1,5 |
| Мэдээллийн сан хөтлөх, мэдээлэл оруулах | Үнэлгээний материалыг эцэслэх | 0,5 |
| | Мэдээлэл хүлээн авах | 0,2 |
| | Мэдээлэл нягтлах | 0,2 |
| | Мэдээлэл оруулах | 0,1 |
| Дундын нэгдсэн сан хөтлөх, мэдээлэл оруулах | Мэдээлэл хүлээн авах | 0,2 |
| | Мэдээллийг нягтлах | 0,2 |
| | Мэдээлэл оруулах | 0,1 |

Аймаг, сум, дүүргийн гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан байгууллага

| | | |
|---|--|-----|
| Зан төлөв, ахуйн нөхцөл байдлын үнэлгээ | Үулзалт товлох, холбогдох мэдээлэл цуглуулах | 6 |
| | Үулзалт хийх, үнэлгээний маягтууд бөглөх | 4 |
| | Үнэлгээг баталгаажуулах, баримт цуглуулах | 2 |
| | Үнэлгээний дүгнэлт гаргах, баримт бүрдүүлэх | 1,5 |
| | Үнэлгээний материалыг эцэслэх | 0,5 |
| Мэргэжлийн зөвлөгөө өгөх | Үулзалт төлөвлөх | 0,2 |
| | Үулзалт, зөвлөгөө | 1,3 |

Сум, хорооны гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан

| | | |
|-----------------------------|--------------------|---|
| Хувийн хэрэг нээж бүрдүүлэх | Мэдээлэл цуглуулах | 4 |
|-----------------------------|--------------------|---|

Мэдээллийг нэгтгэх, загварт оруулах 1

Мэдээллийг нягтлах, эцэслэх 1

Харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага

| | | |
|--|---|-----|
| Мэдээллийн сан хөтлөх, мэдээлэл оруулах | <i>Мэдээлэл хүлээн авах</i> | 0,2 |
| | <i>Мэдээлэл нягтлах</i> | 0,2 |
| | <i>Мэдээлэл оруулах</i> | 0,1 |
| Гэрээ байгуулах, | <i>Судлах /гэрээ байгуулах этгээдийн талаар/</i> | 4 |
| | <i>Гэрээний нөхцлийг бэлтгэх, танилцуулах</i> | 4 |
| | <i>Гэрээний төсөлт бэлтгэх</i> | 1 |
| | <i>Гэрээний нөхцлийг хэлэлцэх, харилцан тохиорх</i> | 2 |
| | <i>Гэрээнд гарын үсэг зурах, батлах</i> | 1 |

Хавсралт 3: Хэрэгжүүлэх үйл ажиллагаа буюу үүргийн талаарх тоон үзүүлэлт

Хүүхдийн төрөл садантайгаа харилцаах харилцааны үнэлгээ хийх

37.4.Хүүхдийн төрөл, садантайгаа харилцахыг хориглосон тухай маргааныг шүүх шийдвэрлэхдээ гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас гаргах хүүхдийн төрөл, садантайгаа харилцаах харилцааны үнэлгээний саналыг үндэслэн шийдвэрлэнэ.

2021 онд гэр бүл цуцлалт = 3390

Үүний 20 хувиар тооцвол = $3390/20 = 170$

Үрчлүүлэх хүүхэд, үрчлэн авах гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ хийх

65.5.Энэ хуулийн 90.1.9-д заасан эрх бүхий байгууллага үрчлүүлэх хүүхэд, үрчлэн авах гэр бүлийн нөхцөл байдалд үнэлгээг хийж Зөвлөлд хүргүүлнэ.

Улсын хэмжээнд жилд 1200-1500 хүүхэд үрчлэгддэг ба хамгийн сүүлийн үеийн статистик мэдээллээр 2021 онд нийт 1261 хүүхэд үрчлэгдсэн ба Улаанбаатар хотод хамгийн өндөр буюу 470, Орон нутгаас хамгийн өндөр нь Баян-Өлгий аймаг ба үрчлүүлсэн хүүхдийн тоо 129 бол хамгийн бага үзүүлэлтэй нь Дорноговь аймаг байна.

| | 2020 | 2021 | 2022 | 1 жилийн дундаж |
|--------------------------|------|------|------|-----------------|
| Хүүхэд үрчлэлт, дотоодод | 1521 | 1241 | 1675 | 1480 |
| Хүүхэд үрчлэлт, гадаадад | 10 | 14 | 10 | 11.33333333 |

Дундын нэгдсэн сан хөтлөх, мэдээлэл оруулах

90.1.5.гэр бүлийн асуудлаар салбар дундын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх;

Жишиг авах тоо: Хүүхэд хамгааллын хариу арга хэмжээ авах шаардлагатай хүүхдийн тоо

Хүүхэд хамгааллын хариу арга хэмжээ авах шаардлагатай хүүхдийн тоог нарийн тодорхой хэлэх боломжгүй ч уг хууль хэрэгжиж эхэлсэн эхний жилүүдэд жилд 9348 хүүхэд хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамрагдах боломжтой гэсэн тооцоог гаргажээ. - Барбертон, С., Гүнчинсүрэн, Э., ‘Монгол Улсын хүүхэд хамгааллын үйлчилгээний төсвийн дүн шинжилгээ ба өртөг тооцоо’, 2016 оны 2-р сар

Хавсралт 4: Шүүхийн байгууллагад шинээр бий болсон үүрэгтэй холбогдох стандарт үйл ажиллагаа

Хүснэгт 28. Шүүхэд үүсэх стандарт үйл ажиллагаа

| Үүрэг | Стандарт үйл ажиллагаа | Минут |
|---|--|-------|
| 1. Хүүхэд үрчлүүлэх эсэх тухай шийдвэр гаргах | Хүсэлттэй танилцах, иргэний хэрэг үүсгэх эсэх асуудлыг шийдвэрлэх | 10 |
| | Шүүх хуралдааны бэлтгэл хангах: /хэргийн материалтай танилцах, нотлох баримт судлах/ | 60 |
| | Шүүхээс гаргах эрх зүйн акт боловсруулах, хянах, албажуулах | 30 |
| | Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой хүсэлт, гомдол шийдвэрлэх | 30 |
| | Мэргэжлийн байгууллагын дүгнэлттэй танилцах | 30 |
| | Хэргийн хөдөлгөөний нэгдсэн систем дэх шүүгчийн ажиллагаа | 30 |
| | Хэргийн материалтай дахин танилцах, /хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой нотлох баримт хангалттай цугласан эсэхийг шалгах, дүгнэх/ | 60 |
| | Шүүх хурлын өмнө гаргасан хүсэлт хэлэлцэх, хүсэлтийг шийдвэрлэх | 20 |
| | Шүүхийн шийдвэр гаргахаар зөвлөлдөх | 30 |
| | Шүүх хуралдааны шийдвэрийг талуудад танилцуулах | 15 |

| | | | |
|--|--|--|------|
| | | Шүүхийн шийдвэр боловсруулах, хянах, албажуулах | 60 |
| | | Шүүх хуралдааны тэмдэглэлийг хянах, баталгаажуулах | 30 |
| | | Хэргийн хөдөлгөөний нэгдсэн систем дэх шүүгчийн ажиллагаа | 33 |
| | | Давж заалдах, хяналтын гомдол хүлээн авах, холбогдох шүүхэд хэргийг хүргүүлэх | 30 |
| | | Шүүхийн шийдвэрт гүйцэтгэх хуудас бичих | 23 |
| | <i>Гадаадад хүүхэд үрчлүүлэх эсэх тухай шийдвэр гаргах</i> | Хүсэлттэй танилцах, иргэний хэрэг үүсгэх эсэх асуудлыг шийдвэрлэх | 20 |
| | | Шүүх хуралдааны бэлтгэл хангах: /хэргийн материалтай танилцах, нотлох баримт судлах/ | 90 |
| | | Шүүхээс гаргах эрх зүйн акт боловсруулах, хянах, албажуулах | 75 |
| | | Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой хүсэлт, гомдол шийдвэрлэх | 45 |
| | | Мэргэжлийн байгууллагын дүгнэлттэй танилцах | 45 |
| | | Хэргийн хөдөлгөөний нэгдсэн систем дэх шүүгчийн ажиллагаа | 42.5 |
| | | Хэргийн материалтай дахин танилцах, /хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой нотлох баримт хангалттай цугласан эсэхийг шалгах, дүгнэх/ | 90 |

| | | |
|--|---|------|
| | Шүүх хурлын өмнө гаргасан хүсэлт хэлэлцэх, хүсэлтийг шийдвэрлэх | 40 |
| | Шүүхийн шийдвэр гаргахаар зөвлөлдөх | 52.5 |
| | Шүүх хуралдааны шийдвэрийг талуудад танилцуулах | 20 |
| | Шүүхийн шийдвэр боловсруулах, хянах, албажуулах | 195 |
| | Шүүх хуралдааны тэмдэглэлийг хянах, баталгаажуулах | 45 |
| | Хэргийн хөдөлгөөний нэгдсэн систем дэх шүүгчийн ажиллагаа | 46.5 |
| | Давж заалдах, хяналтын гомдол хүлээн авах, холбогдох шүүхэд хэргийг хүргүүлэх | 30 |
| | Шүүхийн шийдвэрт гүйцэтгэх хуудас бичих | 38 |
| Хүүхдийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийг өөрчлөх эсэх тухай шийдвэр | Хэрэг, нэхэмжлэлтэй танилцах, иргэний хэрэг үүсгэх эсэх асуудлыг шийдвэрлэх | |

